

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны нэгдүгээр сарын 22-ны 14 цаг 08 минутад эхэлж, 14 цаг 49 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 41 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга Х.Баярлхагваас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>“Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга Х.Баярлхагваас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдлийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.6- д заасныг удирдлага болгон:</p> <p>1. “Албан тушаал бууруулах тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн өдрийн 1395 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх</p> <p>2. “Албан тушаал бууруулах тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн өдрийн 1395 дугаар тушаалыг</p>

		<p>хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн “Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” тус агентлагийн дэргэдэх Салбар зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцох</p> <p>3. Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолыг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу биелүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>УИХ-ын гишүүнээр 2000-2012 онд ажиллаж байсан Л.Гүндалайг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 2000-2012 онд сонгогдон ажиллаж байсан Ламжавын Гүндалайг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайдаар ажиллаж байсан Б.Цэнгэлийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайдын албан тушаалд 2012 онд томилогдон ажиллаж байсан Болдын Цэнгэлийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Ерөнхийлөгчийн зөвлөхөөр 2009 онд</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11,</p>

	<p>ажиллаж байсан Ш.Раднаасэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:  Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхийн албан тушаалд 2009 онд томилогдон ажиллаж байсан Шатарбалын Раднаасэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Төрийн албаны зөвлөлийн Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн Хил хамгаалах ерөнхий газрын 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1-1/114 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:  1. Төрийн албаны зөвлөлийн Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус Газрын Хүний нөөцийн хэлтсийн офицерийн бүрэлдэхүүн хариуцсан хүний нөөцийн ахлах мэргэжилтэн Жаргалын Цолмонг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн томилох  2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрын 5-д “.....Дэд хурандаа Хаянхярваагийн Гантулга” гэснийг “....ахмад Жаргалын Цолмон” гэж өөрчлөх  3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журамд заасан чиг үүргийн дагуу хэрэгжүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Цолмонд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

6	<p>Төрийн албаны зөвлөлийн Соёл, спорт, аялал жуучлалын яам, Эдийн засгийн хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг татан буулгах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн 1 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5 дахь хэсгийг тус тус үндэслэн :</p> <p>1. Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Эдийн засгийн хөгжлийн яамыг татан буулгасантай холбогдуулж Төрийн албаны зөвлөлийн тус яамдын дэргэдэх Салбар зөвлөлийг 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн тус тус татан буулгасанд тооцох</p> <p>2. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын нэгийн 9, 14 дэх хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын нэгийн 8, 14 дэх хэсгүүдийг тус тус хүчингүй болсонд тооцох</p> <p>3. Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хэрэглэж байсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл” 55, 58 дугаартай тэмдэг, холбогдох бичиг, баримтыг хүлээж авах ажил зохион байгуулахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /С.Цэдэндамба/-нд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
---	---	--

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ